

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 01.040.27

Уурын зуух Нэр томъёо, тодорхойлолт	MNS 5086 : 2001
Steam boiler Terms and definitions	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Төвийн Зөвлөлийн 2001 оны 11-р сарын 29-ны өдрийн 74 дүгээр тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2001 оны 12-р сарын 15- ны өдрөөс эхлэн мөрдөнө.

1. Хамрах хүрээ

Энэ стандартаар уурын зуухны үндсэн ойлголт, шинжлэх ухаан, техник, үйлдвэрлэлд хэрэглэж байгаа үндсэн нэр томъёо, тодорхойлолтыг тогтооно.

Энэхүү стандартад нэр томъёо, тодорхойлолтын англи нэрийг (E), орос нэрийг (R) үсгээр тус тус тэмдэглэв.

2. Нэр томъёо, тодорхойлолт

Нэр томъёо	Тодорхойлолт
1. Зуух E. Boiler R. Котел	Органик түлшний шаталтын ба технологийн процессын явцад ялгарсан дулаан болон хаягдал хийн дулааныг ашиглан өгсөн даралт, температуртай уур боловсруулах буюу ус халаах зориулалттай төхөөрөмж Тайлбар: Зуух нь галын хотол, уур халаагуур, ус халаагуур, агаар халаагуур, арал, өрлөг, дулаалга, бүрээс зэргээс бүрдэнэ.
2. Суурин зуух E. Stationary boiler R. Стационарные котел	Хөдөлгөөнгүй суурилуулсан зуух
3. Зуухны төхөөрөмж E. Boiler unit R. Котельная установка	Зуух ба түүний туслах тоноглолууд болох агаар үлээх, түлш бэлтгэх ба өгөх, үнс шаарга зайлуулах ба үнс барих тоноглол, халаах гадаргууг цэвэрлэх хэрэгсэл, уур ба ус дамжуулах хоолой, тэдгээрийн хаалт, арматур, хянах, хэмжих, хамгаалах хэрэгсэл болон ус бэлтгэлийн төхөөрөмж, утаа сорогч, утааны яндан зэргээс бүрдсэн цогцолбор

MNS 5086 : 2001

4. Уурын зуух (суурин) E. Steam boiler R. Паровой стационарный котел	Нэрлэсэн даралт, температуртай уур гаргах зуух
5. Ус халаах зуух (суурин) E. Hot-water boiler R. Водогрейный стационарный котел	Нэрлэсэн температуртай ус халаах зуух
6. Уур-усны зуух (суурин) E. Steam-water boiler R. Пароводогрейный стационарный котел	Уур гаргах ба ус халаах хосолсон зориулалттай зуух
7. Хаягдал дулаан ашиглах зуух E. Waste-heat boiler R. Стационарный котел-утилизатор	Технологийн процесс буюу хөдөлгүүрээс гарч буй хаягдал хийн дулааныг ашиглан уур гаргах болон ус халаах зуух
8. Эрчим хүч-технологийн зуух E. Power and technological boiler R. Энерготехнологический котел	Уур гаргах ба ус халаахын зэрэгцээ галын хотолд нь технологийн дулааны процесс явагдах зориулалттай зуух
9. Цахилгаан зуух E. Electric boiler R. Электрокотел	Цахилгаан энерги ашиглан уур гаргах буюу ус халаах төхөөрөмж
10. Хог шатаах зуух E. Waste fuel boiler R. Мусоросжигающий котел	Хатуу хог, хаягдлыг шатаан дулаан гаргах зуух
11. Хийн хоолойтой зуух E. Gas-tube boiler R. Газотрубный стационарный котел	Багц хоолойн дотуур өндөр температуртай утааны хий явж гадна талд нь орших усыг халаах зуух
12. Усны хоолойтой зуух E. Water-tube boiler R. Водотрубный стационарный котел	Халаах гадаргууг нь утааны хийн урсгал дотор байрласан ус ба уур гүйх хоолойн багц маягаар хийсэн зуух. Тайлбар: Хоолойн багцын байрлалаар нь хэвтээ ба босоо хоолойт гэж ангилна.
13. Тогоотой зуух (барабант) E. Drum (-type) boiler R. Барабанный стационарный котел	Нэг буюу хэд хэдэн (барабантай) тогоотой усны хоолойтой уурын зуух
14. Критик даралтаас (хязгаараас) бага даралтын зуух E. Subcritical pressure boiler R. Стационарный котел докритического давления	Усны критик даралтаас бага даралттай уур гаргах зуух
15. Критик даралтаас өндөр даралтын зуух E. Supercritical pressure boiler R. Стационарный котел сверхкритического давления	Усны критик даралтаас өндөр даралттай уур гаргах зуух

16. Нам даралтын зуух E. Low pressure boiler R. Стационарный котел низкого давления	0.07 МПа (0.7кгс/см ²) хүртэл даралттай уур гаргах зуух
17. Дунд даралтын зуух E. Mean pressure boiler R. Стационарный котел среднего давления	0.07 МПа-аас 10.0 МПа (0.7. . . 100 кгс/см ²) хүртэл даралттай уур гаргах зуух
18. Өндөр даралтын зуух E. High-pressure boiler R. Стационарный котел высокого давления	10.0 МПа-аас 22.5 МПа (100. . .225 кгс/см ²) хүртэл даралттай уур гаргах зуух
19. Хатуу түлшний зуух E. Boiler for solid fuel R. Стационарный котел для твердого топлива	Хатуу түлшний шаталтаас ялгарах дулааныг ашигласан зуух
20. Шингэн түлшний зуух E. Oil-fired boiler R. Стационарный котел для жидкого топлива	Шингэн түлшний шаталтаас ялгарах дулааныг ашигласан зуух
21. Хийн түлшний зуух E. Gas-fired boiler R. Стационарный котел для газообразного топлива	Хийн түлшний шаталтаас ялгарах дулааныг ашигласан зуух
22. Олон түлшний зуух E. Multi fuel boiler R. Многотопливный стационарный котел	Хэд хэдэн төрлийн түлшийг шатаах боломжтой хийсэн зуух
23. Үнс, шааргыг хуурай зайлуулалттай зуух E. Dry-bottom boiler R. Стационарный котел с твердым шлакоудалением	Түлшний шаталтаас үүссэн үнс, шааргыг хатуу төлөв байдалтайгаар галын хотлоос гаргах тоноглолтой зуух
24. Үнс, шааргыг шингэнээр зайлуулалттай зуух E. Wet-bottom or slag-tap boiler R. Стационарный котел с жидким шлакоудалением	Түлшний шаталтаас үүссэн үнс, шааргыг хайлмал шингэн төлөв байдалтайгаар галын хотлоос гаргах тоноглолтой зуух
25. Буцламтгай давхарга бүхий зуух E. Fluidised bed boiler R. Стационарный котел с кипящим слоем	Тасралтгүй хөдөлж буй жижиг ширхэгт инертийн материал ба үнсний давхаргад түлшийг шатаадаг зуух
26. Усны ердийн эргэлттэй зуух E. Natural circulatoion boiler R. Стационарный котел с естественной циркуляцией	Эргэлтийн хүрээнд ус ба уур-усны хольц (ажлын бие)-ын нягтын зөрүүгээр хөдөлгөөнд орох тогтолцоотой зуух

MNS 5086 : 2001

27. Усны албадмал эргэлттэй зуух E. Forced circulation boiler R. Стационарный котел с принудительной циркуляцией	Ажлын биетийг шахуургын тусламжтайгаар эргүүлдэг эргэлтийн хүрээтэй зуух
28. Усны хосолмол эргэлттэй зуух E. Combined circulation boiler R. Стационарный котел с комбинированной циркуляцией	Ажлын биет эргэлтийн зарим хүрээнд буюу ажиллагааны горимд шахуургын тусламжтайгаар бусад хэсэгт буюу горимд ердийн эргэлтээр хөдөлгөөнд ордог тогтолцоотой зуух
29. Шууд урсгалтай зуух E. Once-through boiler R. Прямоточный стационарный котел	Шахуургын тусламжтайгаар бүх халаах гадаргууг ус дайран өнгөрч нэрлэсэн даралт, температуртай уур үйлдвэрлэх буюу ус халаах зуух
30. Буцаах эргэлт бүхий шууд урсгалт зуух E. Once-through boiler with recirculation R. Прямоточный стационарный котел с рециркуляцией	Галлах үед болон бага ачааллын горимд усны хурдыг нэмэгдүүлэх зорилгоор тусгай шахуурга ашиглан усыг буцааж өгөх замаар дахин эргүүлэх тогтолцоотой зуух
31. Ердийн таталттай зуух (суурин) E. Natural-draft boiler R. Стационарный котел с естественной тягой	Гаднах агаар болон яндан дахь утааны хий хоёрын нягтын зөрүүгээс үүссэн гравитацийн хүчээр утаа нь замын бүх эсэргүүцлийг даван туулж гадагшлуулах зуух
32. Тэнцвэржсэн таталттай зуух (суурин) E. Balanced- draft boiler R. Стационарный котел с уравновешенной тягой	Галын хотол буюу хийн хөндийн эхний хэсгийн даралтыг утаа сорогч ба үлээх салхилуурын тусламжтайгаар атмосферийн даралттай ойролцоо байлгах тогтолцоотой зуух
33. Түрэлтэт таталттай зуух E. Pressure-fired boiler R. Стационарный котел с наддувом	Утааны замын эсэргүүцлийг зөвхөн үлээх салхилуурын тусламжтайгаар давснаар утааг нь зайлуулдаг зуух
34. Хийн өндөр даралтат зуух E. Supercharged boiler R. Высоконапорный стационарный котел	Гарч байгаа утааны илүүдэл даралт 0.1 МПа-аас ($1\text{кгс}/\text{см}^2$) их байх зуух
Параметр	
35. Зуухны уурын нэрлэсэн бүтээмж E. Rated steaming capacity R. Номинальная паропроизводительность стационарного котла	Тэжээлийн ус, уурын параметрийн утга хэвийн буюу зөвшөөрөгдөх хязгаарт хэлбэлзэж байхад урт хугацааны турш тасралтгүй боловсруулж байгаа уурын дээд хэмжээ
36. Зуухны дулааны нэрлэсэн чадал E. Rated heating capacity R. Номинальная теплопроизводительность стационарного котла	Тэжээлийн ус, уурын параметрийн утга хэвийн буюу зөвшөөрөгдөх хязгаарт хэлбэлзэж байхад урт хугацааны турш тасралтгүй боловсруулж байгаа дулааны дээд хэмжээ

37. Уурын нэрлэсэн даралт E. Rated steam pressure R. Номинальное давление пара в стационарном котле	Зуух уурын нэрлэсэн бүтээмжээрээ ажиллаж байхад зуухнаас гарч байгаа уурын тооцоот даралт
38. Уурын нэрлэсэн температур E. Rated steam temperature R. Номинальная температура пара в стационарном котле	Зуухны нэрлэсэн бүтээмж, тэжээлийн усны температур, уурын даралт нэрлэсэн утгандаа байх үеийн уурын тооцоот температур
39. Уурын завсрын халалтын нэрлэсэн температур E. Rated reheat temperature R. Номинальная температура промежуточного перегрева пара в стационарном котле	Зуухны бүтээмж, тэжээлийн усны температур, уурын даралт нэрлэсэн утгандаа байх үе дэх завсрын халаагуураас гарч байгаа уурын тооцоот температур
40. Тэжээлийн усны нэрлэсэн температур E. Rated feed water temperature R. Номинальная температура питательной воды в стационарном котле	Зуух нэрлэсэн бүтээмжээрээ ажиллах үед түүний усны экономайзер буюу тогоонд (экономайзергүй үед) орж байгаа тэжээлийн усны шаардлагатай температур
41. Ус халаах зуухны халуун усны нэрлэсэн температур E. Rated hot water temperature R. Номинальная температура горячей воды в водогрейном стационарном котле	Зуухны нэрлэсэн дулааны чадал зөвшөөрөгдөх хязгаартаа хэлбэлзэж байхад түүнээс гарах усны тооцоот температур
42. Зуухны тооцоот даралт E. Design pressure R. Расчетное давление в стационарном котле	Зуухны эд ангиудын бат бөхийн тооцоонд хэрэглэсэн даралт
43. Зуухны ажлын даралт E. Operating pressure R. Рабочее давление пара в стационарном котле	Зуухны тооцоот горимын үед уурын халаагуураас буюу барабанаас (уурын халаагуургүй үед) гарч байгаа уурын даралт
44. Зуухны туршилтын даралт E. Test pressure R. Пробное давление в стационарном котле	Зуухны эд ангиудын бат бөх, битүүмжлэлийг усаар шахаж туршилт хийхэд шаардлагатай техникийн нөхцлөөр тогтоосон даралт
Зуухны эд анги, хэсэг	
45. Зуухны хэсэг (блок) E. Delivery boiler assembly R. Поставочный блок стационарного котла	Тээвэрлэхэд зориулан оврын хэмжээ ба жингээр нь тохируулан угсарсан зуухны хэсгүүд
46. Зуухны цуглуулбар E. Header R. Коллектор стационарного котла	Багц хоолойг нэгтгэсэн ажлын биеийг цуглуулах буюу хуваарилах зориулалттай хоолой
47. Зуухны тогоо (барабан) E. Drum R. Барабан стационарного котла	Ажлын биеийг цуглуулах буюу хуваарилах, уснаас уурыг ялгах, уурыг цэвэрлэх, ус нөөцлөх зориулалттай багтаамжит цилиндр сав
48. Зуухны арал	Зуухны эд ангийг байршуулах, тэдгээрийн

MNS 5086 : 2001

E. Structure R. Каркас стационарного котла	ачааллыг хүлээж авах даацын металл хийц
49. Зуухны өрлөг E. Refractory R. Обмуровка стационарного котла	Зуухны дулааны алдагдлыг бууруулах, нягтралыг хангах зориулалттай галд тэсвэртэй болон дулаан тусгаарлах материалуудаар хийсэн хаалтын хийц
50. Зуухны халаах гадаргуу E. Heating surface R. Поверхность нагрева стационарного котла	Түлшний шаталт болон утааны хийн дулааныг дамжуулан ажлын биет (ус, уур, агаар)-ийг халааж байгаа зуухны үндсэн хэсгүүд
51. Зуухны уур үүсгэх халаах гадаргуу E. Evaporating heating surface R. Парообразующая поверхность нагрева стационарного котла	Зуухны усыг халааж буцалган ууршуулах зориулалттай халаах гадаргуу
52. Цацрагийн халаах гадаргуу E. Radiant heating surface R. Радиационная поверхность нагрева стационарного котла	Галын хотол дотор байрласан цацрагаар дулаан хүлээж авах халаах гадаргуу
53. Цацраг-конвекцоор халаах гадаргуу E. Radiant-convective heating surface R. Радиационно-конвективная поверхность нагрева стационарного котла	Галын хотлын гарах хэсэгт байрлаж цацраг ба конвекцоор дулааныг бараг адил хэмжээтэйгээр хүлээж авах халаах гадаргуу
54. Конвекцийн халаах гадаргуу E. Convective heating surface R. Конвективная поверхность нагрева стационарного котла	Утааны урсгалын замд байрлах конвекцийн дулаан хүлээн авч халаах гадаргуу
55. Ирмэглэсэн халаах гадаргуу E. Finned heating surface R. Оребренная поверхность нагрева стационарного котла	Дулаан дамжуулалтыг эрчимжүүлэх зорилгоор ирмэгтэй хоолойнуудаар хийсэн халаах гадаргуу
56. Зуухны экран E. Waterwall R. Экран стационарного котла	Галын хотол болон хийн хөндийн ханаар эгнэн байрласан босоо багц хоолойноос бүрдэх халаах гадаргуу
57. Хоёр талаасаа халдаг экран E. Division waterwall R. Двусветный экран стационарного котла	Хоёр талаасаа цацрагаас дулаан хүлээн авах зууван экран
58. Зуухны мембран экран E. Membrane wall R. Мембранный экран стационарного котла	Хооронд нь нимгэн ирмэгтэй хавтангаар холбож гагнасан хоолойтой экран
59. Зуухны экраны хавтан E. Waterwall panel R. Панель экрана стационарного котла	Цуглуулбараар холбосон экраны хэсэг

60. Зуухны халаах халхавчин гадаргуу E. Platen R. Ширмовая поверхность нагрева стационарного котла	Хоолойн голчоос 4-5 дахин их хөндлөн алхамтай хавтангуудаас бүрдсэн зуухны галын хотлын дээд хэсэгийн таазны ба арын халаах гадаргууг халхласан халаах гадаргуу
61. Зуухны багц хоолой E. Boiler tube bank R. Котельный пучок стационарного котла	Зуухны хийн хөндийд байрлах дээд, доод тогоонуудыг холбосон уур үүсгэх хоолойнууд
62. Зуухны уур халаагуур E. Superheater R. Пароперегреватель стационарного котла	Зуухны ажлын даралтын үед уурыг ханалтын температураас илүү өндөр температуртай болтол халаах хэрэгсэл
63. Зуухны уур халаагуурын үе E. Superheater stage R. Ступень пароперегревателя стационарного котла	Зуухны уурын халаагуурын дундын цуглуулбараар заагласан хэсэг
64. Зуухны цацрагийн уур халаагуур E. Radiant superheater R. Радиационный пароперегреватель стационарного котла	Зуухны галын хотол буюу хийн хөндийн эхэнд байрлаж ихэнх дулаанаа цацрагаас хүлээн авах уурын халаагуур
65. Зуухны халхавчтай уур халаагуур E. Platen (tube) superheater R. Ширмовый пароперегреватель стационарного котла	Том алхамтай халхавчтай халаах гадаргуугаас бүрдэх цацраг болон конвекцийн дулаан хүлээн авах уурын халаагуур
66. Конвекцийн уур халаагуур E. Convective superheater R. Конвективный пароперегреватель стационарного котла	Зуухны хийн хөндийд байрласан конвекцийн дулаан хүлээн авах уурын халаагуур
67. Зуухны усны экономайзер (халаагуур) E. Economizer R. Экономайзер стационарного котла	Зуухны хийн хөндийд байрлаж утааны хийн дулааныг ашиглан тэжээлийн усыг халаах зориулалттай багц гадаргуу
68. Үл буцалгах экономайзер E. Non-steaming type economizer R. Экономайзер стационарного котла некипящего типа	Тэжээлийн усыг уурших температураас бага температур хүртэл халаах экономайзер
69. Буцалгагч экономайзер E. Steaming type economizer R. Экономайзер стационарного котла кипящего типа	Тэжээлийн усыг уурших температур хүртэл халаан уур-усны хольц үүсгэх экономайзер
70. Бүлэглэсэн экономайзер E. Group economizer R. Групповой экономайзер стационарных котлов	Хэд, хэдэн зуухны тэжээлийн усыг халаах зориулалттай дундын экономайзер

MNS 5086 : 2001

71. Зуухны матмал экономайзер E. Loop economizer R. Змеевиковый экономайзер стационарного котла	Матмал багц хоолойноос бүрдсэн экономайзер
72. Зуухны ирмэгт экономайзер E. Finned tube economizer R. Ребристый экономайзер стационарного котла	Ирмэгтэй хоолойнуудаас бүрдсэн экономайзер
73. Зуухны агаар халаагуур E. Air heater R. Воздухоподогреватель стационарного котла	Хийн хөндийд байрласан, түлшний шаталтад шаардлагатай агаарыг утааны хийн дулааныг ашиглан халаах гадаргуу
74. Гадаргуут агаар халаагуур E. Recuperative air heater R. Рекуперативный воздухоподогреватель стационарного котла	Утааны дулааныг хоолойн ханаар дамжуулан агаар халаах агаарын халаагуур
75. Эргэлдэгч агаарын халаагуур E. Regenerative air heater R. Регенеративный воздухоподогреватель стационарного котла	Утааны хий ба халж байгаа агаартай нэг гадаргуугаараа ээлжлэн харьцах эргэх чигжээстэй агаар халаагуур
76. Ажлын завсрын биетэй агаар халаагуур E. AeroHeater stationary caldron with intermediate R. Воздухоподогреватель стационарного котла с промежуточным теплоносителем	Утааны дулааныг завсрын ажлын биетээр дамжуулан агаарт өгөх агаар халаагуур
77. Хоолойт агаар халаагуур E. Tubular (tube) air heater R. Трубчатый воздухоподогреватель стационарного котла	Босоо багц хоолойнуудаас бүрдсэн халаах гадаргуутай агаар халаагуур
78. Агаарын ялтсан халаагуур E. Plate-type air heater R. Пластинчатый воздухоподогреватель стационарного котла	Ган хуудаснуудаас бүрдсэн халаах гадаргуутай агаар халаагуур
79. Зуухны буух хоолой E. Downcomer tube R. Опускная труба стационарного котла	Зуухны дээд тогоо буюу экран хоолойн дээд цуглуулгуураас доод тогоо буюу экран хоолойн доод цуглуулбарт ус өгөх хоолой
80. Зуухнаас гарах хоолой E. Steam-water riser R. Отводящая труба стационарного котла	Экраны дээд цуглуулбараас уур усны хольцыг дээд тогоо буюу гадна циклонд өгөх хоолой
81. Зуухны дүүжин хоолой E. Support tube R. Подвесная труба стационарного котла	Зуухны халах гадаргууг зүүж бэхлэх усан хөргөлттэй хоолой
82. Зуухны шилжүүлэх хоолой	Зуухны халах гадаргуугийн нэг хэсгээс

E. Crossover tube R. Перепускная труба стационарного котла	нөгөөд ажлын биетийг шилжүүлэх халаалтгүй хоолой
83. Зуухны үлээлгийн хоолой E. Blowdown tube R. Продувочная труба стационарного котла	Зуухны халах гадаргуугийн хэсгүүдээс уур, усыг зайлуулах буюу үлээх зориулалттай хоолой
84. Зуухны уур ялгах хэрэгсэл E. Steam separation device R. Сепараторная труба стационарного котла	Уураас усыг ялгах зориулалттай хэрэгсэл
85. Тогоон доторх уур ялгах хэрэгсэл E. Internal separating device R. Внутрибарабанное паросеперационное устройство стационарного котла	Зуухны дээд тогоон дотор байрласан уураас усан дуслыг ялгах хэрэгсэл
86. Зуухны уур угаах хэрэгсэл E. Steam-washing device R. Паропромывочное устройство стационарного котла	Уурыг тэжээлийн усаар угаан түүний давслагийг бууруулж, чанарыг дээшлүүлэх зориулалттай хэрэгсэл
87. Зуухны тогоон доторх циклон E. Cyclone separator R. Внутрибарабанный циклон стационарного котла	Зуухны тогоон дотор байрласан төвөөс зугтаах хүчний үйлчлэлээр уураас усыг ялгах тоноглол
88. Зуухын гадна циклон E. Outside cyclone R. Выносной циклон стационарного котла	Зуухны тогооны гадна байрласан төвөөс зугтаах хүчний үйлчлэлээр уураас усыг ялгах тоноглол
89. Зуухны үргэлжийн үлээлгийн циклон E. Continuous blowdown separator R. Сеператор непрерывной продувки стационарного котла	Үргэлж үлээлгэх замаар зуухны усны даралтыг бууруулан уур үүсгэж ялгах тоноглол
90. Зуухны үе үе үлээлгийн циклон E. Intermittent blowdown separator R. Сеператор периодической продувки стационарного котла	Үе үеэр үлээлгэх замаар зуухны үусны даралтыг бууруулан уурыг ялгах тоноглол
91. Зуухны уур хөргүүр E. Attemperator R. Пароохладитель стационарного котла	Халсан (хурц) уурын температурыг бууруулан тохируулах тоноглол
92. Шүршүүрэн уур хөргүүр E. Spray type attemperator R. Впрыскивающий пароохладитель стационарного котла	Тэжээлийн ус буюу хувирсан усаар шүршиж уурын температурыг бууруулж, тохируулах уур хөргүүр
93. Гадаргуут уур хөргүүр E. Surface type attemperator R. Поверхностный	Уурын температурыг бууруулан тохируулах усан хөргөлттэй, гадаргуугийн дулаан солилцуур

MNS 5086 : 2001

пароохладитель стационарного котла	
94. Уур-уурын дулаан солилцуур E. Steam-to-steam heat exchanger R. Паропаровой теплообменник стационарного котла	Анхдагч уурын дулааныг ашиглан хоёрдогч уурыг халаах гадаргуугийн дулаан солилцуур
95. Хий-уурын дулаан солилцуур E. Gas-to steam-to steam heat exchanger R. Газопаропаровой теплообменник стационарного котла	Утааны хийн ба анхдагч уурын дулааныг ашиглан хоёрдогч уурыг халаах гадаргуугийн дулаан солилцуур
96. Зуухны галын хотол Галын хотол E. Furnace R. Топка стационарного котла	Органик түлшийг шатаан түүнээс ялгарсан дулааны хэсгийг ашиглан утааны хийг хөргөх, гарсан үнсийг зайлуулах зориулалттай зуухны хэсэг
97. Үнс, шааргыг хатуугаар гаргадаг галын хотол E. Dry-bottom furnace R. Топка стационарного котла с твердым шлакоудалением	Түлш шаталтаас үүссэн үнс, шааргыг доод хэсэгтээ хөргөн хатуу төлөвд шилжүүлэн гадагш зайлуулах тогтолцоотой галын хотол
98. Үнс, шааргыг шингэнээр гаргадаг галын хотол E. Wet-bottom or slag-tap furnace R. Топка стационарного котла с жидким шлакоудалением	Түлш шаталтаас үүссэн үнс, шааргыг доод хэсэгт нь бага зэрэг хөргөн халуун хайлмаг байдлаар нь гадагш зайлуулах бүтэцтэй галын хотол
99. Ул ширэмтэй галын хотол E. Stoker R. Слойная топка стационарного котла	Буталсан хатуу түлшийг үе үеэр нь шатаах зориулалттай дороосоо агаар нэвтрүүлэх ул бүхий галын хотол
100. Гар ажиллагаатай галын хотол E. Hand-operated stoker R. Ручная топка стационарного котла	Түлш өгөлт, шилгээлт, үнс шаарга гаргах ажлыг гараар гүйцэтгэдэг бүтэцтэй галын хотол
101. Хагас механикжсан галын хотол E. Semimechanical stoker R. Полумеханическая топка стационарного котла	Түлш өгөлт, шилгээлт, үнс шаарга гаргах ажлын аль нэгийг нь механикжуулсан бүтэцтэй галын хотол
102. Механикжсан галын хотол E. Mechanical stoker R. Механическая топка стационарного котла	Түлш өгөлт, шилгээлт, үнс шаарга гаргах ажлыг бүгдийг механикжуулсан бүтэцтэй галын хотол
103. Эзлэхүүний галын хотол E. Furnace R. Камерная топка стационарного котла	Тоосон нүүрс, шингэн, хийн түлшийг босоо дөл үүсгэн шатаах бүтэцтэй галын хотол
104. Хуйлруулан шатаах галын хотол	Түлш, агаар өгөлтийн арга ба шатаагуурын өвөрмөц байрлалын тусламжтайгаар түлш,

E. Swir-type furnace R. Вихревая топка стационарного котла	агаарын хольцыг олон дахин эргэлдүүлэн хуйлруулж шатаах бүтэцтэй галын хотол
105. Циклонтой галын хотол E. Cyclone furnace R. Циклонная топка стационарного котла	Түлшний үндсэн хэсгийн эргэлдэх хөдөлгөөний явцад урьд нь шатаах хэсэгтэй эзлэхүүн бүхий галын хотол
106. Дөлт-үелсэн шаталтат галын хотол E. Stoker-spray furnace R. Факельно-слоевая топка стационарного котла	Түлшний томоохон ширхэгтэй хэсгүүдийг ул ширэм дээр үелсэн байдлаар нунтаг хэсгүүдийг түүний дээд хэсэгт дөл үүсгэн шатаах бүтэцтэй галын хотол
107. Зуухны галын хотлын шаталтын хорго E. Primary furnace (in wet-bottom-furnace) R. Камера горения топки стационарного котла	Түлшний үндсэн хэсэг ноцож, шатах галын хотлын хэсэг
108. Зуухын галын хотлын хөргөх хорго E. Secondary furnace (in wet-bottom furnace) R. Камера охлаждения топки стационарного котла	Түлшний гүйцэд шаталтыг явуулан утаа бүхий дулааны зарим хэсгийг ашиглах галын хотлын хэсэг
109. Угтвар галын хотол E. Antechamber R. Предтопок	Түлшийг хатаах, халаах зарим тохиолдолд ноцоох болон шатаах зориулалттай галын хотлын өмнөх хэсэг
110. Галын хотлын доод хүйтэн хэсэг E. Dry bottom R. Холодная воронка стационарного котла	Дулааныг авч үнс, шааргыг хатуу төлөвд шилжүүлэх зориулалттай эзлэхүүн бүхий галын хотлын галд тэсвэртэй доторлогоотой нарийссан доод хэсэг
111. Галын хотлын ёроол E. Bottom R. Под топки стационарного котла	Галын хотлын доод талын хэвтээ буюу бага зэрэг налуу байрлалтай гадаргуу буюу экран
112. Зуухны утааны хийн хөндий E. Flue (-gas) duct R. Газоход стационарного котла	Галын хотлоос гарч байгаа утаа хий дайран өнгөрөх халаах гадаргууг байрлуулсан зуухны хэсэг
113. Тоосон нүүрсний галын хотол E. Pulverized coal (-fired) furnace R. Пылеугольная топка стационарного котла	Тоосон нүүрсээр ажиллах эзлэхүүн бүхий галын хотол
114. Үнсний бункер E. Ash hopper R. Золовой бункер стационарного котла	Зуухны хийн хөндийн доод хэсэгт байрласан утааны хийн урсгалаас ялгарсан үнс цуглуулах хэсэг
115. Шааргын бункер E. Slag hopper R. Шлаковый бункер стационарного котла	Зуухны галын хотлын хүйтэн хэсэг дор байрласан, түлшний шаталтаас үүссэн хатуу шааргыг цуглуулах бункер
116. Шааргын тэвш	Зуухны галын хотлын дор байрласан,

MNS 5086 : 2001

E. Slag basin R. Шлаковая ванная стационарного котла	шингэн шааргыг цуглуулах тэвш
117. Буцалмал давхаргатай галын хотол E. Fluidized bed stoker R. Топка с кипящим слоем	Буталсан хатуу түлшийг буцалмал давхаргад шатаах бүтэцтэй галын хотол
118. Нам температурын буцалмал давхаргатай галын хотол E. Low temperature fluidized bed stoker R. Топка с низкотемпературным кипящим слоем	1000 °C-ээс бага температуртэй буцалмал давхаргатай галын хотол
119. Өндөр температурын буцалмал давхаргатай галын хотол E. High temperature fluidized bed stoker R. Топка с высокотемпературным кипящим слоем	1000 °C-ээс дээш температуртэй буцалмал давхаргатай галын хотол
120. Эргэлдэгч буцалмал давхаргатай галын хотол E. Circulating fluidized bed stoker R. Топка с циркулирующим кипящим слоем	Зуухны галын хотол, түүний гадна байрлах халуун циклоноос бүрдсэн хүрээн дотуур их хурдтай эргэлдэх буцалмал давхаргатай галын хотол
121. Шатаагуур E. Burner R. Горелка	Түлш, шаталтанд шаардлагатай агаарыг зуухны галын хотолд оруулах хэрэгсэл
122. Тоосон нүүрсний шатаагуур E. Pulverized coal burner R. Пылеугольная горелка	Тоос-агаарын хольцыг ба агаарыг галын хотолд оруулах хэсэг
123. Тоос-хийн шатаагуур E. Pulverized coal-gas burner R. Пылегазовая горелка	Тоос агаарын хольц буюу хийн түлш агаарыг галын хотолд оруулах хэрэгсэл
124. Хийн шатаагуур E. Gas burner R. Газовая горелка	Хийн түлш ба агаарыг галын хотолд оруулах хэрэгсэл
125. Мазутын шатаагуур E. Fuel-oil burner R. Мазутная горелка	Мазут ба агаарыг галын хотолд оруулах хэрэгсэл
126. Тоос-мазутын шатаагуур E. Pulverized coal-oil burner R. Пылемазутная горелка	Тоос-агаарын хольц буюу мазут, агаарыг галын хотолд оруулах хэрэгсэл
127. Хий-мазутын шатаагуур E. Gas-oil burner R. Газомазутная горелка	Хийн түлш буюу мазут, агаарыг галын хотолд оруулах хэрэгсэл
128. Тоос-хий-мазутын шатаагуур E. Pulverized coal-gas-oil burner R. Пылегазозомазутная горелка	Тоос-агаарын хольц, хий буюу мазут, агаарыг галын хотолд оруулах хэрэгсэл
129. Хуйлруулагч шатаагуур E. Centrifugal burner	Түлш-агаарын хольц буюу агаарын урсгалыг хуйлруулан галын хотолд оруулах

R. Вихревая горелка	хэрэгсэл
130. Шууд урсгалт шатаагуур E. Direct fuel fired burner R. Прямоточная горелка	Түлш-агаарын хольц ба агаарыг хуйлруулралгүйгээр шууд галын хотолд оруулах хэрэгсэл
131. Урьдчилан холих шатаагуур E. Premix burner R. Горелка предварительного смещения	Түлш-агаарыг дотроо хольж галын хотолд оруулах хэрэгсэл
132. Инжекцийн шатаагуур E. Injector burner R. Инжекционная горелка	Хийн урсгалаар агаарыг сорж галын хотолд оруулах хийн шатаагуур
133. Таазны шатаагуур E. Elevation burner R. Потолочная горелка	Галын хотлын таазанд байрлуулсан шатаагуур
134. Булангийн шатаагуур E. Corner burner R. Угловая горелка	Галын хотлын булангуудад өөд өөдөөс нь харуулан байрлуулсан шатаагуур
135. Галлагааны шатаагуур E. Lighting-up burner R. Растопочная горелка	Зуухыг галлах зориулалттай шатаагуур
136. Өндөр чадлын шатаагуур E. High-capacity burner R. Горелка большой производительности	Түлш агаарын хольцыг их хэмжээгээр галын хотолд өгөх өндөр бүтээмжтэй шатаагуур
137. Бага чадлын шатаагуур E. Light duty burner R. Горелка малой производительности	Түлш агаарын хольцыг галын хотолд багаар өгөх шатаагуур
138. Завсар хэлбэрт шатаагуур E. Split burner R. Щелевая горелка	Нарийн завсартай үлээх гаргалага бүхий шатаагуур
139. Цагираган шатаагуур E. Spring burner R. Кольцевая горелка	Цагирган завсартай үлээх гаргалага бүхий шатаагуур
140. Дугуй шатаагуур E. Circuler (-type) burner R. Круглая горелка	Дугуй хэлбэртэй үлээх гаргалага бүхий шатаагуур
141. Уурын цацлуур E. Steam atomizer burner R. Паровая форсунка	Шингэн түлшийг уураар тоосруулан үлээх цацлуур

ТӨГСӨВ.